

Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын  
2022 оны ... дугаар тушаалын 1 дүгээр  
хавсралт

**МОНГОЛ УЛСЫН ИРГЭНД ТООН ГАРЫН ҮСГИЙН ГЭРЧИЛГЭЭ ОЛГОХ,  
ТҮДГЭЛЗҮҮЛЭХ, СЭРГЭЭХ, ХҮЧИНГҮЙ БОЛГОХ ЖУРАМ**

**Нэг.Нийтлэг үндэслэл**

1.1.Монгол Улсын иргэнд тоон гарын үсгийн гэрчилгээ /цаашид “гэрчилгээ” гэх/ олгох, түүнийг түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгоход энэ журмыг баримтална.

1.2.Тусгай зөвшөөрөл эзэмшигчээс гадаад улсын иргэн, харьяалалгүй хүн, хуулийн этгээд болон нэмэлт тоон гарын үсэг хэрэглэх зорилгоор Монгол Улсын иргэнд олгосон /төрийн албан хаагч, хуулийн этгээдийг төлөөлөх зэрэг/ гэрчилгээтэй холбоотой харилцааг энэ журмаар зохицуулахгүй.

**Хоёр.Гэрчилгээ олгох**

2.1.Монгол Улсын 16 насанд хүрсэн иргэн /цаашид “иргэн” гэх/ анх удаа тоон гарын үсэг авах тухай хүсэлтээ засаг захиргааны нэгжийн харъяалал харгалзахгүй Улсын бүртгэлийн байгууллагын орон нутаг дахь салбар нэгж, цахим үйлчилгээний төв /киоск машин/, хилийн чанадад ажиллаж байгаа Дипломат төлөөлөгчийн газарт биечлэн гаргана.

2.2.Иргэний гаргасан хүсэлтэд Цахим гарын үсгийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3 дахь хэсэгт заасан дараах мэдээллийг тусгана:

2.2.1.хүсэлт гаргагч иргэний эцэг /эх/-ийн болон өөрийн нэр;

2.2.2.иргэний бүртгэлийн дугаар;

2.2.3.хүсэлт гаргагчийн харилцах утасны дугаар, цахим шуудангийн хаяг;

2.2.4.тоон гарын үсэг хэрэглэх эрхэд хязгаарлалт тогтоосон эсэх;

2.2.5.тоон гарын үсгийг хэрэглэн хийх гэрээ хэлцэлийн үнийн дүнгийн хэмжээнд хязгаарлалт тогтоосон эсэх;

2.2.6.гэрчилгээнд тусгах бусад мэдээлэл.

2.3.Улсын бүртгэгч /бүртгэлийн ажилтан/ тоон гарын үсэг авах хүсэлт гаргасан иргэний мэдээллийг иргэний улсын бүртгэлийн цахим мэдээллийн санд биеийн давхцахгүй өгөгдөл /гарын хурууны хээ/-ийн бүртгэлээр таниулж шалгана.

2.4.Иргэний биеийн давхцахгүй өгөгдөл /гарын хурууны хээ/-ийн бүртгэлээр таниулах боломжгүй тохиолдолд иргэний регистрийн дугаар, иргэний бүртгэлийн дугаараар холбогдох мэдээллийг шалгана.

2.5.Иргэний мэдээлэл зөрүүгүй тохиолдолд иргэний эзэмшиж буй утасны дугаар, цахим шуудангийн хаягийг иргэнээс тодруулан авч, мэдээллийн санд нэмж бүртгэн тоон гарын үсгийн гэрчилгээ үүсгэх хүсэлтийг системд илгээнэ. Гэрчилгээ системээс үүсгэгдэж, тоон гарын үсгийн ПИН код, ПУК код, зөвлөмжийг иргэний цахим шуудан, гар утсанд илгээнэ.

2.6.Улсын бүртгэгч /бүртгэлийн ажилтан/ тоон гарын үсгийн гэрчилгээ авах хүсэлт /ИУБ-41 маягт/-ийг мэдээллийн сангаас хэвлэж, иргэнээр холбогдох мэдээллийг шалгуулсны дараа улсын бүртгэгчийн тэмдэг гарын үсгээр баталгаажуулж, маягтын QR кодтой хэсгийг иргэнд олгоно. Улсын бүртгэгч /бүртгэлийн ажилтан/ маягтын үлдэх хэсгийг архивын нэгж үүсгэн холбогдох журмын дагуу Иргэний баримтын архивт хүлээлгэн өгнө.

2.7.Улсын бүртгэгч /бүртгэлийн ажилтан/ иргэний цахим үнэмлэхийн санах ойд тоон гарын үсгийг суулгаж, Цахим гарын үсгийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4 дэх хэсэгт заасан дараах мэдээллийг тайлбарлаж өгнө:

2.7.1.тоон гарын үсэг хэрэглэснээр үүсэх эрх зүйн үр дагавар;

2.7.2.гэрчилгээг эзэмших, ашиглах нөхцөл;

2.7.3.нууцлал, аюулгүй байдлыг хангах арга хэмжээ;

2.7.4.гэрчилгээ эзэмшигчийн буруутай үйл ажиллагааны улмаас нууцлалыг задруулж, алдсанаас үүсэх хариуцлага.

2.8.Монгол Улсын 16 нас хүрсэн иргэн анх удаа иргэний үнэмлэх авах, 25, 45 насанд иргэний үнэмлэхийг солиулах болон Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар Монгол Улсын харъяат болсон, иргэний харъяаллаа сэргээн тогтоолгосон иргэн биеийн давхцахгүй өгөгдөл /гарын хурууны хээ/-ийн бүртгэлд бүртгүүлсэн, иргэний үнэмлэхийг хаяж үрэгдүүлсэн, хүчинтэй байдлыг алдагдуулсан иргэн тоон гарын үсэг авах хүсэлт гаргасан бол тоон гарын үсгийг Хэвлэх үйлдвэрээс иргэний үнэмлэхийн санах ойд бичиж иргэнд олгоно.

2.9.Иргэнд гэрчилгээг 5 жилийн хугацаатай олгоно. Гэрчилгээний хугацаа дууссан тохиолдолд иргэн өөрийн хүчинтэй байгаа тоон гарын үсгийг ашиглан тоон гарын үсэг авах хүсэлтийг цахимаар гаргаж болно.

2.10.Тоон гарын үсэг авах хүсэлт гаргасан иргэний мэдээлэл зөрүүтэй бол улсын бүртгэгч /бүртгэлийн ажилтан/ хүсэлтийг даруй буцаана.

2.11.Цахим гарын үсгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2, 8 дугаар зүйлийн 8.5 дахь хэсэгт заасны дагуу иргэн иргэний үнэмлэхээс бусад тээгч төхөөрөмжид тоон гарын үсэг авах хүсэлтийг гаргаж болно.

### **Гурав.Иргэнд олгосон гэрчилгээг түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох**

3.1.Улсын бүртгэлийн байгууллага Цахим гарын үсгийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэгт заасны дагуу иргэнд олгосон гэрчилгээг түдгэлзүүлнэ.

3.2.Иргэн гэрчилгээг түдгэлзүүлэх хүсэлтээ Улсын бүртгэлийн байгууллагын орон нутаг дахь салбар нэгж, хилийн чанадад ажиллаж байгаа Дипломат төлөөлөгчийн газарт бичгээр гаргасан тохиолдолд улсын бүртгэгч /бүртгэлийн ажилтан/ ажлын 8 цагийн дотор, төрийн үйлчилгээний нэгдсэн систем /e-mongolia/, Улсын бүртгэлийн байгууллагын цахим үйлчилгээний төв /киоск машин/, гар утасны аппликейшныг ашиглан цахимаар гаргасан тохиолдолд нэн даруй шийдвэрлэнэ.

3.3.Цахим гарын үсгийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.3, 17.1.4 дэх заалтад заасан эрх бүхий байгууллагын шийдвэрийг үндэслэн гэрчилгээг түдгэлзүүлэх бөгөөд энэ тухай гэрчилгээ эзэмшигчид даруй мэдэгдэж, түдгэлзүүлсэн тухай мэдээллийг иргэний цахим шууданд илгээнэ.

3.4.Иргэн Цахим гарын үсгийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.4 дэх хэсэгт заасны дагуу түдгэлзүүлсэн гэрчилгээг сэргээх хүсэлт гаргасан тохиолдолд улсын бүртгэгч, бүртгэлийн ажилтан гэрчилгээг даруй сэргээнэ.

3.5.Хуульд заасны дагуу эрх бүхий байгууллагын шийдвэрээр гэрчилгээг түдгэлзүүлсэн шалтгаан арилсан тохиолдолд улсын бүртгэгч /бүртгэлийн ажилтан/ гэрчилгээг ажлын 8 цагийн дотор сэргээж, гэрчилгээ эзэмшигчид холбогдох цахим шуудангаар мэдэгдэнэ.

3.6.Улсын бүртгэгч /бүртгэлийн ажилтан/ Цахим гарын үсгийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт заасан үндэслэлээр гэрчилгээг хүчингүй болгоно.

### **Дөрөв.Бусад**

4.1.Улсын бүртгэгч /бүртгэлийн ажилтан/ Цахим гарын үсгийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь заалт, 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсэгт заасны дагуу иргэний гаргасан хүсэлт болон иргэнд олгосон гэрчилгээ түүнийг түдгэлзүүлж, сэргээж, хүчингүй болгосон талаарх бүртгэлийг тогтмол хөтөлж, архивын нэгж үүсгэн цаасан болон цахим хэлбэрээр хадгална.

4.2.Улсын бүртгэлийн байгууллагаас иргэнд олгосон, түдгэлзүүлсэн, хүчингүй болгосон гэрчилгээний дугаарыг өөрийн цахим хуудас болон төрийн үйлчилгээний нэгдсэн системд байршуулж, мэдээллийг тогтмол шинэчилнэ.

---оОо---

Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын  
2022 оны ... дугаар тушаалын 2 дугаар  
хавсралт

ТООН ГАРЫН ҮСЭГ АНХ УДАА АВАХ ХҮСЭЛТ ХҮЛЭЭН АВАХ МАЯГТ

1. Бүртгэл хөтөлсөн:  
Аймаг, нийслэл: \_\_\_\_\_  
Сум, дүүрэг: \_\_\_\_\_
  2. Иргэний регистрийн дугаар: \_\_\_\_\_
  3. Иргэний бүртгэлийн дугаар: \_\_\_\_\_
  4. Иргэний төрсөн он, сар, өдөр: \_\_\_\_\_
  5. Эцэг, эхийн нэр: \_\_\_\_\_
  6. Иргэний овог: \_\_\_\_\_
  7. Өөрийн нэр: \_\_\_\_\_
  8. Байнга оршин суугаа газрын хаягийн мэдээлэл:  
\_\_\_\_\_
  9. Иргэний харилцах утасны дугаар:  
\_\_\_\_\_
  10. Иргэний имэйл хаяг:  
\_\_\_\_\_
- Хүсэлт гаргагчийн:  
\_\_\_\_\_  
/гарын үсэг/  
Бүртгэл хөтөлсөн:  
Улсын бүртгэгч /бүртгэлийн ажилтан/
11. Бүртгэл хөтөлсөн:  
.....он.....сар.....өдөр
  12. Гэрчилгээний хүчинтэй байх хугацаа  
\_\_\_\_\_
  13. Тоон гарын үсэг хэрэглэх эрхэд хязгаарлалт тогтоосон эсэх:  
Тийм \_\_\_\_\_  
Үгүй \_\_\_\_\_
  14. Тоон гарын үсгийг хэрэглэн хийх гэрээ хэлцэлийн үнийн дүнгийн хэмжээнд хязгаарлалт тогтоосон эсэх:  
тийм \_\_\_\_\_  
үгүй \_\_\_\_\_
  15. Тийм бол үнийн дүнгийн хэмжээ:  
\_\_\_\_\_  
\_\_\_\_\_

тэмдэг

/гарын үсэг/

/гарын үсгийн тайлал/

---oO---